

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2022.07.14 № СТА/22-26.
таний -ны № -т

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлтийн тайллан

Бид “Женкотур бюро” ХК-ний 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүтийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн бөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүтийн тайлангийн тэмдэглээс бүрдсэн санхүүгийн тайландаа аудит хийж гүйцэтгээдээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний одреерх санхүүгийн байдал, тухайн тайлант жилийн ўл ажиллагааны орлого үр дүн, өмчийн бөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлгэдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүтийн Тайлантгийн Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын ёс зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЕЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба загээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалитай бөгөөд зохицой үндэслэл болно гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайландаа хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна. Бидний гаргасан тайландаа материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Санхүүгийн тайландаа Удирдлагыг болов Засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлагыг нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланга бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлагыг хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж

*Санхүүгийн тайланд Удирдлага болон Засаглах удирдлагын хүлээх хариуцлага
(үргэлжлэл)*

өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээн.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр болдог сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдөрөг төсөөллиөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэзэх, шаардлагатай бол өөдөрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээн.

Компанийн засаглах эрх мэдэл бүхий этгээлүүд нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээн.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бухэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлээс ангид эсх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нэгдсэн дунгэрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлгэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлож үнзлэсэн, тэдгээр эрсдэлд тохиорохуйц аудитын зорилтыг боловсруулан хэрэлжүүлж, зөвсний дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хувалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдуулд багтсан байж болно.
- ✓ Аудитын зохицой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байтаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулагын зохицой байдлыг үнзлэн.
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохицой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц өргэлзээ үүсгэхүйц үйл явдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (ургэлжлэл)

Бид засаглах удирдлагатай аудитын ширхэг, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хялттын сүл талуудын талаар харилсан.

Хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаарх тайлан

Бид “Женкотур Бюро” ХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, менген гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж дүгнэлтээ гаргасан.


Бид санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэх явцдаа санхүүгийн тайлагналтай холбогдохгүрүүлж байгууллагас гаргасан хууль, дүрэм, журмын дагш мордолтийн талаар тест гүйцэтгэсэн бэгээд доорх зүйлээс бусад зүйлсийн хувьд Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөөгүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоо бидэнд мэдэгдээгүй.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1-р зүйлд засны дагуу зөвхөн “Женкотур Бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулахад зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэжлийн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2022 оны 03 сарын 14.



ДАЛТАН ЦАЦГААН
Захирад, ММНБ